



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 4/260

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2020 оны 8 дугаар хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Онцгой байдлын байгууллагын радио холбоо зохион байгуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гамшгийн шуурхай удирдлагын газар (хурандаа Б.Мандахгэрэл)-т даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/861 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

00002427

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН РАДИО ХОЛБОО
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Онцгой байдлын байгууллагын радио холбооны системийг төлөвлөх, зохион байгуулах, ашиглахад нэгдсэн арга зүйгээр хангахад оршино.

1.2. Байнгын болон гамшгийн үеийн радио холбоог зохион байгуулж, ашиглахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3. Онцгой байдлын байгууллагын холбоо зохион байгуулах үйл ажиллагаанд үндэсний эрх ашгийг хамгаалсан, нэгдсэн бодлого, төлөвлөлттэй, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үнэн зөв, цаг хугацаандаа шуурхай байх зарчмыг баримтална.

1.4. Холбооны үндсэн үүрэгт:

1.4.1. Удирдлагын;

1.4.2. Харилцан ажиллагааны;

1.4.3. Зарлан мэдээллийн;

1.4.4. Ар тал хангалтын холбоог багтаан ойлгоно.

1.5. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.5.1. "Радио холбоо" гэж радио төхөөрөмж ашиглан төрөл бүрийн мэдээллийг тэмдэгт, дохио, дуу, дүрс болон бусад хэлбэрээр нэвтрүүлэх, хүлээн авахыг;

1.5.2. "Үндсэн үелзэл" гэж мэдээлэл солилцох ажлын үелзэл буюу сувгийг;

1.5.3. "Бэлтгэл үелзэл" гэж мэдээлэл солилцох ажлын үелзэл буюу сувагт саатуулга бий болох үед ахлах радио станцын шийдвэрээр шилжин ажиллах үелзэл буюу сувгийг;

1.5.4. "Ахлах радио станц" гэж радио холбоонд ахлах даргын холбоог хангаж байгаа радио станцыг;

1.5.5. "Радио тор" гэж радио холбоог зохион байгуулахдаа өгөгдсөн нэг үелзэл дээр олон радио станц ажиллаж, ахлах радио станцын мэдээг нэгэн зэрэг хүлээн авч, холбооны сахилгыг мөрдөж харилцан мэдээлэл солилцохыг;

1.5.6. "Радио чиг" гэж радио холбоог зохион байгуулахдаа өгөгдсөн нэг үелзэл дээр зөвхөн 2 радио станц ажиллаж, холбооны сахилгыг мөрдөж харилцан мэдээлэл солилцохыг;

1.5.7. "Байнгын хүлээн авалт" гэж томилгоот бүлэг үүрэг гүйцэтгэхээр байнгын байрлалаас гараад буцаж ирэх хүртэлх хугацаанд тогтоосон цагуудад холбоонд орж мэдээлэл дамжуулахаас гадна, тогтмол хүлээн авалтын горимд шилжиж ажиллахыг.

Хоёр. Радио холбооны төлөвлөлт, зохион байгуулалт

2.1. Онцгой байдлын байгууллагын радио холбооны системийг дараах байдлаар төлөвлөнө. Үүнд:

2.1.1. Үүсэж болзошгүй эрсдэлийг тооцсоны үндсэн дээр холбооны системийн шийдэл гаргах, дэд бүтцийг зураглах, суурь сүлжээ байгуулах, өргөтгөн сайжруулах ажлыг зохион байгуулна.

2.1.2. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, үндэсний эрх ашигт нийцэхүйц, систем хоорондын уялдаа, зохицон ажиллах нийцлийг хангасан байна.

2.1.3. Техник технологи, ашиглалт үйлчилгээ, хүний нөөцийн хувьд найдвартай, байнгын бэлэн байдлыг хангана.

2.1.4. Гамшгийн үед ашиглах холбооны тоног төхөөрөмжийн болон сувгийн нөөц, боломжит бүх төрлийн нөөцийн үнэлгээ хийнэ.

2.1.5. Радио холбооны тоног төхөөрөмжийн бүртгэлийн нэгдсэн санг үүсгэж эдэлгээ норм, норматив, ашиглалтын хугацаа, нөхөн хангалтын судалгааг гаргана.

2.1.6. Холбооны шугам, зангилааг радио чимээ болон гамшиг, аюулт үзэгдэл, осол, эрсдэлтэй хүчин зүйлүүдийн нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг авна.

2.1.7. Тоног төхөөрөмж болон антены байгууламжийн гамшигт тэсвэртэй байдлыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.1.8. Гамшгийн дараа яаралтай сэргээн босгох төлөвлөгөөтэй байна.

2.1.9. Радио холбооны системд бүхэлд нь үр ашгийн шинжилгээ хийж үнэлж дүгнэнэ.

2.1.10. Холбоо тогтоох арга зам, холбооны техник хэрэгсэл ашиглах дэс дарааллыг тогтоож, хүч хэрэгслийг хуваарилах холбоо зохион байгуулалтын бүдүүвч зургийг үйлдэнэ.

2.1.11. Цагийн байдал өөрчлөгдсөн тохиолдолд холбооны хүч хэрэгслийг шилжүүлэн байршуулах, хослуулан ашиглах боломжийг бүрдүүлнэ.

2.1.12. Холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх хуваарь, төлөвлөгөөг жил бүр батлуулж хэрэгжүүлнэ.

2.2. Байнгын болон гамшгийн үеийн радио холбоог дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

2.2.1. Холбооны хүч хэрэгслийн бэлэн байдал, хүрэлцээ, харилцан ажиллах байгууллагуудын холбооны системийн нөхцөл байдал, үйл ажиллагаа явуулж буй бүс нутаг дахь холбооны сүлжээний байдал, газар орны онцлог, холбооны системийг дэлгэх хугацаа, гамшиг, аюулт үзэгдлийн нөлөөллийг тооцсоны үндсэн дээр холбоог зохион байгуулна.

2.2.2. Холбооны хэрэгсэл, мэдээлэл дамжуулах аргууд, тэдгээрийн хугацаа, цаг агаар, өдөр шөнө, газар орны нөхцөл байдлыг харгалзан радио холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сонгож ашиглана.

2.2.3. Онцгой байдлын ерөнхий газар, Үндэсний аврах бригад, Бүсийн төв, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсүүд нь холбооны бүх төрлийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон суурин болон хөдөлгөөнт холбооны зангилаатай байна.

2.2.4. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай “Чиглэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу холбоог зохион байгуулна.

2.2.5. Цагийн байдлын өөрчлөлтийн дагуу радио холбооны системийг богино хугацаанд тогтоогдсон хүрээнд өөрчлөн байгуулж удирдагдах боломжтой байхаар зохион байгуулна.

2.2.6. Холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, холбоочдын ур чадварыг дээшлүүлэх хээрийн дадлага сургуулийг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулна.

2.2.7. Гамшгийн үеийн холбоо зохион байгуулахад анги салбар, зангилаа болон харилцан ажиллаж буй байгууллага, тэдгээрийн хүч хэрэгслүүдийн харилцан ажиллагааны журмыг мөрдөнө.

2.2.8. Өдөр, шөнийн горимд ажиллах үндсэн болон бэлтгэл үелзэлтэй байх бөгөөд богино долгионы тархалтад нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллөөс хамаарч Холбоо, техник, цахим мэдээллийн аюулгүй байдал хариуцсан бүтцийн нэгж өөрчилж болно.

2.2.9. Гамшгийн үеийн радио холбоог бүх түвшинд радио тор үүсгэн (Хавсралт 1) зохион байгуулна.

2.2.10. Радио торд ажиллаж байгаа радио станц хэрэглэгчид мэдээ, мэдээллийг нэгэн зэрэг хүлээн авч, хариу илтгэхдээ холбооны сахилгыг мөрдөж, хатуу эрэмбэтэйгээр цуварч холбоонд орно.

2.2.11. Ахлах радио станц нь тухайн торд ажиллаж байгаа радио станцуудаас ажлын тогтоосон журам, холбооны сахилга болон мэдээлэл солилцоонд хяналт тавина.

2.2.12. Радио станц хэрэглэгчийн дуудлагыг Онцгой байдлын байгууллагын хэмжээнд харилцан ажиллагааны холбоо зохион байгуулалтын үед давхцахгүй байхаар баталж мөрдүүлэх ба шуурхай бүлэг байнгын байрлалаас гарсан дарааллаар нь таних үг, тооноос бүрдсэн дуудлагатай (Ерөө-1) байхаар олгоно.

Ерөө-Тухайн радио станц хэрэглэгчийг таних үг

1-Радио торд хэрэглэгчийг ялгах тоо /1, 2, 3, .../

2.2.13. Радио станц хэрэглэгч нь холбоонд орохдоо өөрийн дуудлагыг хэрэглэн мэдээ хүлээн авахыг зөвшөөрөх, баталгаа өгөх байдлаар (Хавсралт 2) холбоо тогтооно.

2.2.14. Радио станцад үндсэн болон бэлтгэл үелзэл тохируулах ба радио долгионы тархалт муудах, саатуулга бий болох үед ахлах радио станцын зөвшөөрлөөр бэлтгэл үелзэлд шилжүүлнэ.

2.2.15. Онцгой байдлын ерөнхий газраас төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагуудтай тогтоосон цагуудад холбоонд орж холбооны чанар байдлыг шалгах ба холбооны чанарыг харилцагчийн сонсголын байдлаар (5-Онц, 4-Сайн, 3-Дунд, 2-Муу) үнэлнэ.

2.2.16. Мэдээ, мэдээллийг хүлээн авах, дамжуулахдаа (Хавсралт 3) радио холбоонд орсон бүртгэл хөтлөлтийг хийнэ.

2.2.17. Тусгай хэрэглээний радио давтамж нь төрийн нууцын зэрэглэлд хамаардаг тул шинээр ашиглалтад оруулах радио станцын программын тохиргоог Онцгой байдлын ерөнхий газрын Холбоо, техник, цахим мэдээллийн аюулгүй байдал хариуцсан бүтцийн нэгжид хийнэ.

2.2.18. Шинээр ашиглалтад оруулах радио холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмж бүрд техник ашиглалтын паспорт (Хавсралт 4) үүсгэж, бүртгэл хөтлөлтийг хийнэ.

Гурав. Эрх, үүрэг

3.1. Холбоо, техник, цахим мэдээллийн аюулгүй байдал хариуцсан бүтцийн нэгж дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

3.1.1. Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлоготой уялдуулан Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрх зүйн баримт бичгийг боловсруулж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.2. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд тусгай хэрэглээний радио давтамжийн нэгдсэн төлөвлөлтийг хийх;

3.1.3. Шинээр ашиглалтад оруулах радио холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжид программын тохиргоог хийх, аюулгүй байдлыг хангах, хуваарилалтыг батлуулж, ашиглалтад хяналт тавих;

3.1.4. Радио холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн эдэлгээ нормыг тооцож, засвар үйлчилгээ, нөхөн хангалтыг зохион байгуулах;

3.1.5. Бүсийн хэмжээнд холбоо зохион байгуулахад хүндрэл үүссэн тохиолдолд хүн хүч, техник хэрэгслийн дэмжлэг үзүүлэх;

3.1.6. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллагын хэмжээнд холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг засварлах боломжгүй тохиолдолд албан хүсэлтийг үндэслэн дэмжлэг үзүүлэх;

3.1.7. Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, мэдээллийг радио холбоогоор дамжуулахгүй байхад хяналт тавих;

3.1.8. Алба хаагчдыг сургаж мэргэшүүлэх.

3.2. Бүсийн төвийн холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

3.2.1. Холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн байнгын бэлэн байдлыг хангах;

3.2.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод ажиллах холбоочинг томилж, шаардлагатай холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг олгох, хяналт тавих;

3.2.3. Бүсийн хэмжээнд холбоог төлөвлөх, зохион байгуулах;

3.2.4. Аймгийн хэмжээнд холбоо зохион байгуулахад хүндрэл үүссэн тохиолдолд хүн хүч, техник хэрэгслийн дэмжлэг үзүүлэх;

3.2.5. Аймгийн хэмжээнд холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг засварлах боломжгүй тохиолдолд албан хүсэлтийг үндэслэн дэмжлэг үзүүлэх;

3.2.6. Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, мэдээллийг радио холбоогоор дамжуулахгүй байхад хяналт тавих;

3.2.7. Бүсийн хэмжээнд дадлага, сургалтыг зохион байгуулж, алба хаагчдыг сургаж, мэргэшүүлэх.

3.3. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллагын холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

3.3.1. Холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн байнгын бэлэн байдлыг хангах;

3.3.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод ажиллах холбоочинг томилж, шаардлагатай холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг олгох, хяналт тавих.

3.3.3. Аймгийн хэмжээнд холбоог төлөвлөх, зохион байгуулах;

3.3.4. Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, мэдээллийг радио холбоогоор дамжуулахгүй байхад хяналт тавих;

3.3.5. Дадлага, сургалтыг зохион байгуулж, алба хаагчдыг сургаж, мэргэшүүлэх;

3.3.6. Холбооны техник хэрэгслийн хадгалалт, иж бүрдэл, бүрэн бүтэн байдлыг жилд 2-оос доошгүй удаа шалгаж, техник ашиглалтын паспорт, эзэмшигчийн бүртгэл болон бусад бүртгэл, тайлан тооцоог гаргаж холбогдох саналыг хүргүүлэх.

3.4. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод ажиллах холбоочин дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

3.4.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэхдээ холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг шалгаж, хүлээлцэх бүртгэл хөтлөх;

3.4.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэхдээ холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хариуцах;

3.4.3. Газар орны нөхцөлд тохируулан холбоо барих цэгийг тодорхойлж, холбооны техник хэрэгслийг дэлгэн байгуулах;

3.4.4. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг тогтоосон цагуудад дээд шатны байгууллагад дамжуулах;

3.4.5. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдлөг болгон ажиллана.

Дөрөв. Радио холбооны тоног төхөөрөмжийн ашиглалт

4.1. Техник ашиглалтад холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг эвдрэл, гэмтэлгүй хэвийн найдвартай ажиллуулахын тулд авч хэрэгжүүлж буй техникийн болон зохион байгуулалтын иж бүрэн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1. Хэрэглэгч нь нэг байршилд байгаа бусад радио төхөөрөмжүүдэд давтамжийн суваг, чадлын хувьд нөлөөлөхгүйгээр ашиглана.

4.1.2. Антены байгууламжийг аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан, зориулалтын цамхагт байрлуулан аянга зайлуулагч болон газардуулгыг хийж, орчиндоо аюулгүй байхаар ашиглана.

4.1.3. Техник ашиглалтын паспортод радио холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ажиллуулсан болон гэмтлийг засварласан талаарх бүртгэлийг хийнэ.

4.1.4. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод ашиглах холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ажиллагааг шалгаж, хүлээлцсэн бүртгэл (Хавсралт 5) хөтөлнө.

4.1.6. Радио холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа (Хавсралт 6)-г тооцож, эдэлгээ нормыг тогтооно.

4.1.7. Тоног төхөөрөмжийн эдэлгээний хугацаа дууссан, техникийн гэмтэл гарч, засварлах боломжгүй тохиолдолд техникийн гэмтлийн тодорхойлолтыг (Хавсралт 7) үйлдэнэ.

4.1.8. Радио станцын батареийг цэнэглэхдээ бүртгэл (Хавсралт 8) хөтөлж, эдэлгээний хугацааг тогтооно.

4.1.9. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллагын холбооны суурин болон хөдөлгөөнт зангилаанууд нь өөр хоорондоо холбооны найдвартай байдлыг хангах ба хөдөлгөөн үйлдэх, цагийн байдлын өөрчлөлтөд тасралтгүй байхаар бүрдүүлсэн байна.

4.1.10. Хэт богино долгионы радио станцын үйлчлэх хүрээг нэмэгдүүлэхийн тулд нэвтрүүлэх ба хүлээн авах антенуудыг өндөрлөг газарт байрлуулна.

4.1.11. Богино долгионы радио холбооны чанарыг сайжруулахын тулд чиглэлийн үйлчилгээтэй антеныг ашиглана.

4.2. Газар орны нөхцөлд тохируулан холбоо зохион байгуулахад дараах зүйлийг анхаарна. Үүнд:

4.2.1. Говь, цөл газарт радио станцыг нарны шууд тусгал, хэт халалтаас хамгаалах, хүчтэй салхи, шороон шуурга радио станцад шуугиан үүсгэхээс сэргийлэх арга хэмжээ авна.

4.2.2. Уулархаг бүсэд радио долгионы энергийн шингээлт, сарнилт, ойлт явагдахаас сэргийлж радио станцын антеныг шууд харалтын зайд, өндөрлөг болон уулын бэлээс зайдуу газарт дэлгэн байрлуулна.

4.2.3. Усны мандалд хөдөлгөөнт холбоо зохион байгуулахад тоног төхөөрөмжийг ус, чийгийн хамгаалалттай, битүүмжлэлийг сайтар хангасан, зориулалтын (marine) радио станцыг сонгож ашиглана.

4.2.4. Уурхайн гүнд олон төрлийн цахилгаан хэрэгслийн хамт радио станцыг ашиглахдаа цахилгаан, соронзон орны нөлөөлөлд орох эрсдэлийг тооцно.

4.2.5. Агаараас эрэн хайх, аврах ажиллагааны үед хоёр талын (газар-агаар, газар-газар) радио холбоог хангаж ажиллана.


Тав. Хариуцлага

5.1. Журмыг зөрчсөн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цэргийн нийтлэг дүрмийн дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

5.2. Алба хаагчид хуулийн хариуцлага хүлээлгэсэн эсэхээс үл хамаарч учирсан хохирлыг бүрэн барагдуулна.

..... о О о

ГАМШГИЙН ҮЕИЙН РАДИО ХОЛБОО ЗОХИОН БАЙГУУЛАХ БҮДҮҮВЧ



(F3)-Удирдлагын холбооны суваг

(F4)-Салбар, бүлгийн харилцан ажиллагааны холбооны суваг

РАДИО ХОЛБОО ТОГТООХ ДАРААЛАЛ

Радио станцын дуудлага	Нэвтрүүлэх	Хүлээн авах	Баталгаажуулах
Ерөө-1	“Ерөө” “Ерөө-1”-ийг сонсож байна уу хариу		
Ерөө		Би “Ерөө” “Ерөө-1”-ийг сонсож байна.	
Ерөө-1	“Ерөө” радио мэдээ хүлээн авна уу.		
Ерөө		Би “Ерөө” хүлээн авахад бэлэн	
Ерөө-1	Би “Ерөө-1” шуурхай бүлэг ажиллаж дууслаа.		
Ерөө			Би “Ерөө” шуурхай бүлэг ажиллаж дууслаа гэж хүлээн авлаа зөв үү ?
Ерөө-1			Би “Ерөө-1” зөв
Ерөө-1	Дараагийн холбоонд орох цаг 11 цаг 30 минут		
Ерөө		Би “Ерөө” байнгын хүлээн авалтад байна.	

РАДИО ХОЛБООНД ОРСОН БҮРТГЭЛ

Хүлээн авсан		Хүлээн авсан, нэвтрүүлсэн мэдээний агуулга	Нэвтрүүлсэн	
Огноо, цаг	Дуудлага		Огноо, цаг	Дуудлага

ТЕХНИК АШИГЛАЛТЫН ПАСПОРТ

1. Тоног төхөөрөмжийн нэр _____
2. Тоног төхөөрөмжийн марк, сериал _____
3. Үйлдвэрлэсэн орны нэр _____
4. Үйлдвэрлэсэн огноо _____
5. Ашиглалтад оруулсан огноо _____
6. Хаана суурилуулсан _____

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ДАГАЛДАХ ХЭРЭГСЛҮҮД

д/д	Дагалдах хэрэгслийн нэр	Тоо хэмжээ

УРСГАЛ ЗАСВАРЫН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

д/д	Он, сар, өдөр, цаг, минут	Засварын тухай мэдээлэл	Сольсон сэлбэг хэрэгсэл	Засвар хийсэн хүний нэр, албан тушаал

ҮЗЛЭГ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ

д/д	Он, сар, өдөр, цаг, минут	Ямар үйлчилгээ хийсэн эсэх	Эвдрэл гэмтэл, засварын тухай	Үзлэг, үйлчилгээ хийсэн хүний нэр, албан тушаал

ЭЗЭМШИГЧ НЬ СОЛИГДСОН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

д/д	Он, сар, өдөр, цаг, минут	Шалтгаан	Хүлээлгэн өгсөн	Хүлээн авсан

РАДИО ХОЛБООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦАА

д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Ашиглалтын хугацаа /жил/
1	Богино долгионы суурин радио станц	8
2	Богино долгионы автомашины радио станц	7
3	Богино долгионы үүргэвчийн радио станц	6
4	Хэт богино долгионы суурин радио станц	8
5	Хэт богино долгионы автомашины радио станц	7
6	Хэт богино долгионы үүргэвчийн радио станц	6
7	Хэт богино долгионы гар радио станц	5
8	Хэт богино долгионы дахин дамжуулах станц	8

Дугаар:20-...

ТЕХНИКИЙН ГЭМТЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Тоног төхөөрөмжийн нэр:

Эд ангийн нэр, загвар, сериал дугаар:

Ашиглалтад орсон огноо:

Гэмтлийн шалтгаан:

Санал:

Шийдвэр

Техникийн тодорхойлолт гаргасан:

Эзэмшигч :

20.. оны.....сарынөдөр

РАДИО СТАНЦЫН БАТАРЕЙ ЦЭНЭГЛЭЛТИЙН БҮРТГЭЛ

Д/д	Радио станцын марк	Сериал дугаар	Хүчдэлийн хэмжээ /вольт/	Гүйдлийн хэмжээ /ампер/	Он, сар, өдөр	Эхэлсэн цаг, минут, секунд	Дууссан цаг, минут, секунд	Гарын үсэг

.....оОо.....